



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/50-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn Архангай аймаг 2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Гэрээгээр аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Захирал С.Оргил Утас: 9919-7346 Цахим хаяг: Shinjlenmagadlahui.ezsh. audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.25 № 109
танай _____-ны № _____-г

БУЛГАН СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
А.БАТЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Булган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэг дурдсан алдаа зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Булган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар багш, ажилтнуудад 7000.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлтийн дэмжлэгийг батлагдсан цалингийн сангаас хавтгайруулан олгосон байна. Энэ зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.1 дэх заалтад нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Булган сумын Хүүхдийн цэцэрлэг нь 120 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд 2023 онд 116 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулсан. Тайлант онд БШУЯ-аас хандив тусламжаар 2,983.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 26.7 хувиар өссөн байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын үнэлгээний төвөөс багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдсэн

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 үндсэн зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн БШУГ-аас 89.9 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,454,256.7	108,020,075.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,610,606.7	90,787,975.13
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,610,606.7	90,787,975.13
3121	Төгрөг	6,610,606.7	90,787,975.13
31211	Төрийн сангийн харилцах	6,610,606.7	90,787,975.13
35	БАРАА МАТЕРИАЛ	18,843,650.00	17,232,100.00
351	Түүхий эд материал	67,500.00	67,500.00
3511	Тусгай зориулалттай материал	67,500.00	67,500.00
354	Хангамжийн материал	18,776,150.00	17,164,600.00
3541	Бичиг хэргийн материал	300,000.00	300,000.00
3542	Аж ахуйн материал	18,375,650.00	16,764,600.00
3547	Бусад хангамжийн материал	100,500.00	100,500.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,009,507,489.44	988,502,998.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,009,507,489.44	988,502,998.67
392	Биет хөрөнгө	999,713,489.44	978,708,998.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,038,869,258.57	1,038,869,258.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	-56,785,125.28	-76,160,714.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,578,422.00	39,561,922.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,681,898.72	-25,108,739.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,985,045.70	29,985,045.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,716,002.83	-29,901,563.62
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,098,115.46	13,098,115.46
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,098,115.46	-13,098,115.46
39217	Ном	1,463,790.00	1,463,790.00
393	Биет бус хөрөнгө	9,794,000.00	9,794,000.00
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	-275,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,794,000.00	9,794,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,034,961,746.14	1,096,523,073.80
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,034,961,746.14	1,096,523,073.80
51	Засгийн газрын хувь оролцоо	1,034,961,746.14	1,096,523,073.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	233,621,946.46	233,621,946.46
51101	Өмч: - төрийн	233,621,946.46	233,621,946.46
512	Хуримтлагдсан үр дүн	389,089,706.15	450,651,033.81
5121	Өмнөх үеийн үр дүн	389,089,706.15	389,089,706.15
5122	Тайлант үеийн үр дүн		61,561,327.66
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	412,250,093.53	412,250,093.53
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,034,961,746.14	1,096,523,073.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,417,632,287.2	472,627,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,108,783,987.20	3,158,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,108,783,987.20	3,158,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		175,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,108,783,987.20	2,983,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	308,848,300.00	469,469,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	276,585,100.00	446,669,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	276,585,100.00	446,669,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,263,200.00	22,800,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,263,200.00	22,800,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	324,021,837.83	411,066,572.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	324,021,837.83	411,066,572.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	322,416,603.31	410,891,572.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,025,397.92	271,695,615.94
210101	Үндсэн цалин	177,846,014.60	194,323,628.67
210102	Нэмэгдэл	30,944,856.51	65,678,458.99
210104	Урамшуулал	9,234,526.81	11,693,528.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,065,302.92	33,158,415.63
210201	Тэтгэврийн даатгал	19,084,466.00	22,623,627.36
210202	Тэтгэмжийн даатгал	2,245,184.22	2,661,629.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,796,207.33	2,101,378.36
210204	Ажилгүйдлийн даатгал	448,976.89	518,134.84
210205	Эрүүл мэндийн даатгал	4,490,468.48	5,253,646.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,097,238.94	21,800,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,056,400.00	4,500,000.00
210302	Түлш, халаалт	10,817,467.94	16,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	223,371.00	800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,559,690.00	3,948,900.00
210401	Бичиг хэрэг	460,000.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,099,690.00	
210408	Бараа материал акталсны зардал		3,948,900.00

Архангай аймгийн Булган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	31,527,759.00	41,190,900.00
210502	Хоол, хүнс	31,527,759.00	41,190,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	630,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	630,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	480,000.00	942,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	480,000.00	942,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,031,214.53	37,155,140.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,591,270.00	10,819,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,160,300.00	2,347,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,279,644.53	23,987,990.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,605,234.52	175,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,605,234.52	175,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,605,234.52	175,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,093,610,449.37	61,561,327.66
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,093,610,449.37	61,561,327.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	308,848,300.00	469,644,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		175,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		175,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		175,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	308,848,300.00	469,469,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	276,585,100.00	446,669,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	276,585,100.00	446,669,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,263,200.00	22,800,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,263,200.00	22,800,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	302,237,693.30	385,467,031.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	302,237,693.30	385,467,031.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	300,632,458.78	385,292,031.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,025,397.92	271,695,615.94
210101	Үндсэн цалин	177,846,014.60	194,323,628.67
210102	Нэмэгдэл	30,944,856.51	65,678,458.99
210104	Урамшуулал	9,234,526.81	11,693,528.28

Архангай аймгийн Булган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,065,302.92	33,158,415.63
210201	Тэтгэврийн даатгал	19,084,466.00	22,623,627.36
210202	Тэтгэмжийн даатгал	2,245,184.22	2,661,629.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,796,207.33	2,101,378.36
210204	Ажилгүйдлийн даатгал	448,976.89	518,134.84
210205	Эрүүл мэндийн даатгал	4,490,468.48	5,253,646.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,097,238.94	21,800,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,056,400.00	4,500,000.00
210302	Түлш, халаалт	10,817,467.94	16,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	223,371.00	800,000.00
2105	Нормативт зардал	31,516,419.00	41,190,900.00
210502	Хоол, хүнс	31,516,419.00	41,190,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	630,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	630,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	480,000.00	782,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	480,000.00	782,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,818,100.00	15,664,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,818,100.00	13,316,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	2,347,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,605,234.52	175,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,605,234.52	175,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,605,234.52	175,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,610,606.70	84,177,368.43
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	6,610,606.70	84,177,368.43
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,610,606.70
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		90,787,975.13

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгэ эний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	233,621,946.46		401,942,243.98	1,047,814,283.97
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	233,621,946.46		401,942,243.98	1,047,814,283.97
D08	Тайлант үеийн үр дүн			61,561,327.66	61,561,327.66
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	233,621,946.46		450,651,033.81	1,096,523,073.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	476,079,800.00	385,292,031.57	90,787,768.43	80.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	476,079,800.00	385,292,031.57	90,787,768.43	80.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	476,079,800.00	385,292,031.57	90,787,768.43	80.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	346,410,700.00	271,695,615.94	74,715,084.06	78.43
210101	Үндсэн цалин	227,256,200.00	194,323,628.67	32,932,571.33	85.51
210102	Нэмэгдэл	107,799,800.00	65,678,458.99	42,121,341.01	60.93
210104	Урамшуулал	11,354,700.00	11,693,528.28	-338,828.28	102.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,301,800.00	33,158,415.63	10,143,384.37	76.58
210201	Тэтгэврийн даатгал	29,444,600.00	22,623,627.36	6,820,972.64	76.83
210202	Тэтгэмжийн даатгал	3,464,200.00	2,661,629.01	802,570.99	76.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,771,300.00	2,101,378.36	669,921.64	75.83
210204	Ажилгүйдлийн даатгал	693,200.00	518,134.84	175,065.16	74.75
210205	Эрүүл мэндийн даатгал	6,928,500.00	5,253,646.06	1,674,853.94	75.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,800,000.00	21,800,000.00		100
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.00	4,500,000.00		100
210302	Түлш, халаалт	16,500,000.00	16,500,000.00		100
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	800,000.00		100
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал	47,064,200.00	41,190,900.00	5,873,300.00	87.52
210502	Хоол, хүнс	47,064,200.00	41,190,900.00	5,873,300.00	87.52
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00		100
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00		100
2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	782,600.00	782,600.00		100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	782,600.00	782,600.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,720,500.00	15,664,500.00	56,000.00	99.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,372,800.00	13,316,800.00	56,000.00	99.58
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,347,700.00	2,347,700.00		100
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	476,079,800.00	469,469,400.00	6,610,400.00	98.61

Архангай аймгийн Булган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	453,279,800.00	446,669,400.00	6,610,400.00	98.54
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	453,279,800.00	446,669,400.00	6,610,400.00	98.54
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,800,000.00	22,800,000.00		100
132001	Орон нутгийн төсвөөс	22,800,000.00	22,800,000.00		100
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,610,606.70	-6,610,606.70	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		90,787,975.13	-90,787,975.13	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
3	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	19.5	19.5		100.00
6	Удирдах ажилтан	2	2		100.00
7	Гүйцэтгэх ажилтан	6.5	6.5		100.00
8	Үйлчлэх ажилтан	11	11	0	100.00
9	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	120	116		100.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй. Харин нийт 7,000.0 мянган төгрөгийн зөрчил илэрснийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 1 зөрчилтэй асуудал нь тогтоосон материаллаг байдлын дүн 3,332.6 төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2023 оны А/12 дугаар тушаалаар цалингийн сангаас багш, ажилтнуудад түлшний хөнгөлөлтийн дэмжлэгт нийт 7,000.0 мянган төгрөгийг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 “Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгссөн албан шаардлага: Батлагдсан төсвөөс зориулалт бусаар дэмжлэгийг хавтгайруулан олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 22-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2024 оны 06 дугаар сарын 20-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Цалин сангаас түлшний хөнгөлөлт олгосон	1	7,000.00			1	7,000.00							
Дүн	1	7,000.00			1	7,000.00							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
9 мэдээллийг хугацаа хоцроосон.	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Нийт дүн	1	0					1	0